




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2017/4



АГУУЛГА

	Хуудасны Дугаар
I. Нийгмийн үзүүлэлт	3
I.1 Эрүүл мэнд	3
I.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд	7
I.3 Нийгмийн халамж	9
I.4 Гэмт хэрэг	10
II. Эдийн засгийн үзүүлэлт	12
II.1 Төсөв	12
II.2 Хэрэглээний үнэ	13
II.3 Мал аж ахуй	16
II.4 Аж үйлдвэр	17
II.5 Аж ахуй нэгж байгууллага	18

**Сонгинохайрхан дүүргийн
нийгэм, эдийн засгийн байдал
(2017оны эхний IV сарын байдлаар)**

I. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



I.1 Эрүүл мэнд

Оны эхний 4 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 2117 эхээс 2129 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 552 хүнээр бага байна. Он гарсаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 32 гарсан нь өмнөх оны мөн үеэс 21.96 хувиар буурсан бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл 10 гарсан нь өмнөх оны мөн үеэтэй ижил байна. Тайлант хугацаанд эхнийн эндэгдэл 1 гарсан байна.

Хүснэгт 1. Төрөлт, нас баралтын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2016-04 сар		2017-04 сар	
	Бодит тоо	1000 хүн амд	Бодит тоо	1000 хүн амд
Төрсөн эх		2657		2117
Амьд төрсөн нярай		2681		2129
Нийт нас баралт		530		475
0-1 насны хүүхдийн эндэгдэл	41	15.29	32	15.03
1-5 насны хүүхдийн эндэгдэл	10	3.73	10	4.70
Эхийн эндэгдэл	0	0	1	47.00

Тайлант хугацаанд 0-1 настай хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 15.03 промилл ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.26 промиллоор буурсан бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл тайлант хугацаанд 4.70 промилл байгаа нь өмнөх оноос 0.97 промиллоор өссөн үзүүлэлттэй байна.

Зураг-1. Төрөлт



2016-04 сар

2017-04 сар

Тайлант хугацаанд халдварт өвчнөөр өвчлөгсөд 1627 бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад халдварт өвчний гаралт 55.73 хувиар буюу 2048 тохиолдолоор буурсан байна. 2016 оны 4-р сард 10000 хүнд ногдох халдварт өвчин 121.88 промилл байсан бол 2017 онд 52.23 промилл болж 69.65 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.


Халдварт өвчний гаралтыг өмнөх онтой харьцуулан харвал цусан суулга 44 тохиолдолоор, Салхин цэцэг 134 тохиолдлоор, Улаан эсэргэнэ 21 тохиолдолоор, Тэмбүү 35 тохиолдолоор, Трихомониаз 9 тохиолдолоор, Улаанууд 2 тохиолдолоор, ГХА 90 тохиолдолоор, Хачигт рикеттикоз 1 тохиолдолоор, Exanthema subitum b08.2 63 тохиолдолоор, Энтеровируст цэврүүт фарангит b08.5 4, Төрөлийн тэмбүү 2 тохиолдолоор тус тус өссөн байна. Харин Гепатит 10 тохиолдолоор, гахайн хавдар 3 тохиолдолоор, Бруцеллэз 1 тохиолдолоор, Хоолны хордлого 2 тохиолдолоор, Улаанбурхан 2368 тохиолдолоор, Заг хүйтэн 44 тохиолдлоор, Шинэ илэрсэн сүрьеэ 21 тохиолдлоор тус тус буурсан байна. Тайлант хугацаанд салхинцэцэг өвчин нийслэлд хамгийн их буюу 2463 тохиолдол бүртгэгдсэний 393 буюу 15.96 хувь нь тус дүүргийнх, ГХА өвчин 2266 тохиолдол бүртгэгдсэний 359 нь буюу 15.84 хувь нь тус дүүргийнх байна.

Хүснэгт 2. Халдварт өвчний гаралт, төрлөөр

Үзүүлэлтүүд	2016		2017		УБ хот	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Бүгд халдварт өвчин	3675	121.88	1627	52.23	8907	65.34
Үүнээс цочмог халдварт өвчин	3111	103.2	1084	34.80	6445	47.28
Цусан суулга	61	2.02	105	3.37	456	3.35
Улаан эсэргэнэ	77	2.55	98	3.15	563	4.13
Менингит	0	0.00	1	0.03	2	0.01
Гепатит	29	0.96	19	0.61	88	0.65
Салхинцэцэг	259	8.59	393	12.62	2463	18.07
Гахайн хавдар	15	0.50	12	0.39	52	0.38
Сальмонеллөз	5	0.17	6	0.19	36	0.26
Бруцеллөз	5	0.17	4	0.13	13	0.10
Ёлом	11	0.36	11	0.35	36	0.26
Халдварт эритема	6	0.20	2	0.06	26	0.19
ГХА өвчин	269	8.92	359	11.52	2266	16.62
Улаанууд	0	0.00	2	0.06	8	0.06
Хачигт рикеттикоз	0	0.00	1	0.03	2	0.01
Хоолны хордлого	3	0.10	1	0.03	17	0.12
Улаанбурхан	2371	78.63	3	0.10	6	0.04
Exanthema subitum b08.2		0.00	63	2.02	391	2.87
Энтеровируст цэврүүт фарангит b08.5		0.00	4	0.13	20	0.15
Тэмбүү	211	7.00	246	7.90	916	6.72
Заг хүйтэн	90	2.98	46	1.48	289	2.12
Шинэ илэрсэн сүрьеэ	230	7.63	209	6.71	797	5.85
Трихоминиаз	33	1.09	42	1.35	399	2.93
Төрөлийн тэмбүү	2	0.07	4	0.13	10	0.07

Тайлант хугацаанд дүүргийн эмнэлэгийн байгууллагууд 546754 үзлэг хийсний 41.61 хувь нь урьдчилан сэргийлэх, 18.20 хувь нь гэрийн үзлэг байна. Дүүргийн эмнэлэгийн орны тоо 380 бөгөөд тайлант хугацаанд 45248 ор хоног ашигласан байна. Халдварт бус өвчлөл 29944 гарсан байна.

Зураг- 2. Халдварт өвчний гаралт оноор, төрлөөр



Оны эхний 4 сарын байдлаар 2768 эх шинээр жирэмсэний хяналтанд орсон байна. Хяналтанд орсон эхчүүдээс 3.29 хувь нь цус багадалттай, 0.98 хувьд нь трихомониаз, 0.72 хувьд нь заг хүйтэн, 4.55 хувьд нь тэмбүүгийн өвчлөл илэрсэн байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 62.38 хувь нь жирэмсэний эхний 3 сартайдаа хяналтанд орсон байна.

Хүснэгт 3. Нас баралт, өвчлөлийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт		Тоо
Нас баралт	Нас баралт-Бүгд	274
	Эрэгтэй	151
	Эмэгтэй	123
	Эмнэлэгт нас барсан хүний тоо	22
	Гэртээ нас барсан хүний тоо	252
Эрт илрүүлгийн үзлэг	Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо	11820
	Эрэгтэй	4859
	Эмэгтэй	6961
	Давтан үзлэг	4520
	Оношлогдсон артерийн гипертензи	375
	Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо	8326
	Эрэгтэй	3479
	Эмэгтэй	4847
	Давтан үзлэг	2810
	Оношлогдсон чихрийн шижин	180
	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүний тоо	20579
	Эрэгтэй	13852
	Эмэгтэй	6727
	Давтан үзлэг	2879
Оношлогдсон хорт хавдрын тоо	31	
Жирэмсний хяналт	Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүдийн тоо-Бүгд	4437
	Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо-Бүгд	2768
	Эхний 3 сартайд	2436
	4-6 сартайд	299
	7 ба түүнээс дээш сартайд	33
	Жирэмсний хяналтад шинээр авсан эмэгтэйчүүд цусны шинжилгээнд хамрагдсан тоо	2768
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсний эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээ	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо	91
	Трихомониаз илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	2768
	Үүнээс: эерэг	27
	Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	2768
	Үүнээс: эерэг	20
	Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	2768
	Үүнээс: эерэг	126
Амбулаторийн өвчлөл	ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	2768
	Үүнээс: эерэг	0
	Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл-Бүгд	29944
	Шинэ	17231
	Хуучин	12589
	Хорт хавдрын өвчлөл	124
	Осол гэмтлийн өвчлөл	14
	Томуу, томуу төст өвчин (J09-J11)	80
	0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчин (K52.0-K52.9)	3
	0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин (J00-J06, J20-J22)	705
	0-5 хүртэлх насны жинлэсэн хүүхдийн тоо	73354
	Туранхай /жин, өндрийн үзүүлэлт/	493
	Тураалтай /жин, насны үзүүлэлт/	212
	Өсөлтийн хоцрогдолтой /өндөр, насны үзүүлэлт/	328
	А амин дэм уусан	694
	Д амин дэм уусан	13441
Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн	2253	


Оны эхний 4-р сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 11820 хүн хамрагдсанаас 58.89 хувь нь буюу 6961 хүн нь эмэгтэйчүүд байна. Үүнээс 38.24 хувь нь давтан үзлэгт хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2 - ын эрт илрүүлгийн үзлэгт 8326 хүн хамрагдсанаас 58.22 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 4. Ахмад настны эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо
Нийт ахмад настны тоо	24883
Эмэгтэй	14406
Хөгжлийн бэрхшээлтэй	2751
Архаг өвчтэй	12381
Өрхийн эмнэлгээр үйлчлүүлсэн ахмад настны тоо	11239
Гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаанд хамрагдсан ахмадын тоо	550
Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ахмадын тоо	4589
Эмнэлгийн хэрэгслийн хангамж үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо /Нүдний шил, хиймэл шүд, таяг/	384
Рашаан сувилал, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан ахмадын тоо	633
Эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан ахмадын тоо	3166
Биеийн тамир дасгал хөдөлгөөнөөр тогтмол	754
Хөгшрөлтийн тэнэгрэл буюу зөнөгрөлийн тохиолдлын тоо	84
Зүрх судасны кабенитын үзлэг	1430
Урьдчилан сэргийлэх үзлэг	473
Ахмад настны тоо	58
Дотоод шүүрлийн кабинетын үзлэг	1430
Урьдчилан сэргийлэх үзлэг	63
Ахмад настны тоо	29
Архины хордлогын улмаас хэвтэж эмчлүүлсэн хүний тоо	3
Архины хордлогын улмаас яаралтай тусламж авсан хүний тоо	590
Архины хордлогын улмаас нас барсан хүний тоо	5

Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад эхний 4 сарын байдлаар 24883 ахмад настан эмчилгээнд хамрагдсанаас 57.89 хувь буюу 14406 хүн нь эмэгтэйчүүд, 11.06 хувь нь буюу 2751 хүн нь хөгжлийн бэрхшээлтэй, 47.75 хувь нь буюу 12381 хүн нь архаг өвчтэй байна.

Зураг-3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрлөөр, хувиар



Дүүргийн хэмжээнд 0-18 насны нийт 750 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Үүнээс: 9.87 хувь нь буюу 74 хүүхэд харааны, 10.13 хувь буюу 76 хүүхэд сонсголын, 7.20 хувь буюу 54 хүүхэд хэл ярианы, 19.33 хувь буюу 145 хүүхэд хөдөлгөөний, 15.20 хувь буюу 114 хүүхэд оюун ухааны, 13.47 хувь буюу 101 хүүхэд хавсарсан, 24.80 хувь буюу 186 хүүхэд нь бусад гэсэн шалтгаантай байна.



I.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд

Оны эхний 4 сарын байдлаар бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 1782 болсон байна. Үүнээс 24 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь ангилж үзэхэд дипломын болон бакалаврын дээд боловсролтой 640 хүн буюу 35.91 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 124 хүн буюу 6.96 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 117 хүн буюу 6.57 хувь, бүрэн дунд боловсролтой 754 хүн буюу 42.31 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Бүртгэлтэй ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшин, насны бүлгээр

Ажил хайгч иргэн /сарын эцэст/	Боловсролын түвшнээр							
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор
1782	4	20	65	754	117	124	640	58
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Насны бүлгээр						
		15-24	25-34	35-44	45-54	55-59	60+	
	24	222	765	445	270	65	15	

Нийт бүртгүүлсэн ажил хайгч иргэний 863 буюу 48.43 хувь нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд бүртгэлтэй ажил хайгч иргэнээс 39 хүн ажилд зуучлагдан орсон байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдээс ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлгээр харвал 15-24 насны залуучууд 25.64 хувь, 25-34 насныхан 53.85 хувь, 35-44 насныхан 10.26 хувь, 45-54 насныхан 10.26 хувь, 55-59 насныхан 3.33 хувийг тус тус эзэлж байна.

Зураг -4. Ажилд зуучлагдан орсон иргэд, боловсролын түвшингээр



1	20	1	1	15	1
Магистр, доктор	Дипломын болон бакалаврын	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь

Ажилд зуучлагдан орсон иргэдийн боловсролын түвшинг харвал дээд боловсролтой 51.28 хувь, тусгай дунд боловсролтой 2.56 хувь, бүрэн дунд боловсролтой 38.46 хувийг тус тус эзэлж нь байна.

2017 оны 4-р сарын байдлаар бүртгэлтэй ажил хайгч иргэний тоо 624-өөр нэмэгдэж, 629 хүн бүртгэлээс хасагдсан байна.

Хүснэгт 6. Ажил хайгч иргэний тоо 2017 оны 4-р сарын байдлаар

Үзүүлэлтүүд		Бүгд
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/		1787
Үүнээс: Эмэгтэй		850
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн		624
Үүнээс: Эмэгтэй		330
Ажил хайж байгаа шалтгаанаар	Шилжин суурьшсан	82
	Сургуулиа орхисон /гарсан, чөлөө авсан/	17
	Сургууль төгсөөд ажилгүй байгаа	151
	Гадаадаас эргэж ирсэн	20
Ажлаас чөлөөлөгдсөн/ халагдсан	Мэргэжил, ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх	0
	Тэтгэвэрт гарсан	4
	Орон тооны цомхотголд орсон	199
	Байгууллага татан буугдсан	54
	Бусад	43
Тайлант хугацаанд хасагдсан		629
Ажилд зуучлагдан орсон		39
Байгууллагын хариуцлагын хэлбэрээр	Хувьцаат компани	1
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	26
	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	0
	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	0
	Төрийн бус байгууллага	0
	Төсөвт байгууллага	11
	Бусад	1
Насны бүлгээр	15 - 24	10
	25 - 34	21
	35 - 44	4
	45-54	4
	55-59	0
	60+	0
Боловсролын түвшингээр	Магистр, доктор	1
	Дипломын болон бакалаврын	20
	Тусгай мэргэжлийн дунд	1
	Техникийн болон мэргэжлийн	1
	Бүрэн дунд	15
	Суурь	1
	Бага	0
	Боловсролгүй	0
Ажил хайгч иргэн /сарын эцэст/		1782
Үүнээс: Эмэгтэй		863



I.3 Нийгмийн халамж

Оны эхний 4-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн эхний үлдэгдэл 77.3 сая төгрөг байгаагаас 82.28 хувийг нийгмийн халамжийн санд, 0.07 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжид, 0.30 хувийн алдарт эхийн одонгийн тусламжид, 0.09 хувийг олон нийтийн оролцоонд халамж үйлчилгээний харилцаанд /ОНОТХҮХ/, 13.85 хувийг хүнс тэжээл хөтөлбөрт тус тус хуваарилсан байна. Тайлант хугацаанд 10562.8 сая төгрөгийн санхүүжилтийн 13.59 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжид, 2.18 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид, 20.62 хувийг алдарт эхийн одонгийн тусламжид, 8.16 хувийг насны хишигт тус тус хуваарилсан байна. Харин зарлагын 49.94 хувийг нийгмийн халамжийн санд, 10.74 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжид, 24.64 хувийг алдарт эхийн одонгийн тусламжид, 9.89 хувийг насны хишигийн зардалд тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 7. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2017.04 сар /мян.төг/

Үзүүлэлт	Дүн
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	77,336.9
Нийгмийн халамжийн сан	63,625.8
Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	55.9
Алдарт эхийн одонгийн тусламж	233.8
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	2,638.1
ОНОТХҮЙлчилгээний харилцах	71.8
Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны харилцах	10,711.5
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ОРЛОГО	10,562,818.0
Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1,435,439.3
Алдарт эхийн одонгийн тусламж	2,161,000.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	230,000.0
Халамжийн сангийн санхүүжилт	5,505,397.4
Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	366,245.1
Насны хишиг	862,130.0
Бусад орлого	2,606.2
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА	10,151,595.6
Нийгмийн халамжийн сан	5,511,188.2
Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1,211,023.6
Алдарт эхийн одонгийн тусламж	2,097,954.1
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	92,075.0
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	384,750.0
ОНОТХҮЙлчилгээний зардал	1.0
Насны хишиг	833,875.5
Банкны шимтгэл	813.6




I.4 Гэмт хэрэг

Оны эхний 4-р сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо нийт 848 болсон бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 254 гэмт хэргээр буюу 23.05 хувиар буурсан байна. Гэмт хэргийн илэрүүлэлт 64.81 хувьтай байна.

Гэмт хэргийн гаралтыг хороогоор харвал оны эхний 4-р сарын байдлаар хамгийн их гэмт хэрэг гарсан хороо нь 22-р хороо бөгөөд 55 хэрэг бүртгэгдсэн байна. Тус хороонд гарсан нийт гэмт хэргийн 24 буюу 43.64 хувь нь хулгайн гэмт хэрэг байна. Харин хамгийн бага хэрэг бүртгэгдсэн 3-р хороо бөгөөд 12 хэрэг бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн гаралтыг төрлөөр нь харвал хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 21 буюу нийт гэмт хэргийн 2.48 хувь, дээрмийн гэмт хэрэг 28 буюу нийт гэмт хэргийн 3.30 хувь, ББМУ гэмт хэрэг 238 буюу 28.10 хувь, хулгайн гэмт хэрэг 265 гарсан нь нийт гэмт хэргийн 31.25 хувийг тус тус эзэлж байна. Мөн танхайрах гэмт хэрэг 71, залилангийн хэрэг 58 гарсан байна.

Зураг- 5. Хулгайн гэмт хэргийн хэргийн тоо, хороогоор 2017.04 сар



Хүснэгт 8. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, төрлөөр, хороогоор

	Хүнийг санаатай алах	Бусдыг амиа хорлоход хүргэх	ББМБУ	Хүчиндэх	Хулгай	Булаах	Дээрэмдэх	Залилан	Танхайрах	ТХХАБАЖЭ	Бусад	Бүгд дүн
1-р хороо	0	1	11	1	4	0	1	4	4	0	2	28
2-р хороо	0	0	15	0	14	0	0	0	2	2	1	34
3-р хороо	1	0	3	0	5	0	0	0	0	0	3	12
4-р хороо	0	0	7	0	4	1	1	2	1	1	4	21
5-р хороо	1	1	4	0	7	0	1	1	1	3	1	20
6-р хороо	1	0	5	1	5	0	2	4	10	2	3	33
7-р хороо	0	0	9	2	10	0	1	0	1	5	8	36
8-р хороо	0	0	7	0	3	4	2	0	5	1	0	22
9-р хороо	0	0	3	0	8	0	0	0	3	1	3	18
10-р хороо	0	0	6	0	2	0	1	0	2	3	2	16
11-р хороо	0	0	3	0	5	0	1	2	4	1	3	19
12-р хороо	0	0	4	0	4	0	1	1	1	0	4	15
13-р хороо	0	0	1	0	10	0	1	1	1	2	3	19
14-р хороо	0	0	9	0	7	0	2	1	2	0	4	25
15-р хороо	1	0	3	0	8	1	2	1	2	1	2	21
16-р хороо	1	0	4	0	7	0	2	4	0	1	2	21
17-р хороо	0	0	2	0	6	1	1	5	0	3	3	21
18-р хороо	0	0	13	1	7	1	0	3	3	6	4	38
19-р хороо	1	1	15	0	9	0	0	4	5	1	5	41
20-р хороо	0	0	11	0	12	1	1	8	2	3	4	42
21-р хороо	1	0	7	0	8	0	0	1	0	0	2	19
22-р хороо	0	2	13	1	24	0	1	4	3	3	4	55
23-р хороо	0	0	9	0	4	0	1	1	3	1	2	21
24-р хороо	1	0	9	1	15	0	2	1	2	0	3	34
25-р хороо	0	1	14	0	6	0	1	1	4	2	0	29
26-р хороо	1	0	14	0	18	0	0	1	2	1	4	41
27-р хороо	0	0	10	1	4	0	0	3	3	4	4	29
28-р хороо	1	0	5	0	3	0	0	0	2	1	0	12
29-р хороо	0	0	11	0	15	0	2	3	0	1	4	36
30-р хороо	0	1	4	0	6	0	1	0	2	1	1	16
31-р хороо	1	2	2	1	14	1	0	0	1	2	0	24
32-р хороо	1	0	5	0	11	0	0	2	0	7	4	30
Бүгд	12	9	238	9	265	10	28	58	71	59	89	848

II. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



II.1 Төсөв

Оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогыг 4324.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 15.00 хувиар буюу 648.7 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 3739.9 сая төгрөг болсон байна.

Орон нутгийн төсвийн орлогын 49.37 хувь буюу 1814.4 сая төгрөгийг татварын орлогоор, 4.46 хувийг буюу 163.8 сая төгрөгийг татварын бус орлогоор 46.17 хувийг нийслэлээс авсан санхүүгийн дэмжлэгээс тус тус бүрдүүлсэн байна. Нийт татварын орлогын 54.62 хувь нь орлогын албан татвараас, 44.06 хувь нь бусад татвар / төлбөр хураамж/ -аас тус тус бүрдсэн байна.

Бусад татвар / төлбөр хураамж/-ын 22.58 хувийг буюу 180.5 сая төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжаас, 77.42 хувийг буюу 618.8 сая төгрөгийг хог хаягдал үйлчилгээний хураамжаас тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн орлого, зарлага / мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,324,061.0	3,675,316.0	85.0
А. Урсгал орлого	2,424,650.0	1,978,231.6	81.6
1. Татварын орлого	2,194,650.0	1,814,435.7	82.7
1. Орлогын албан татвар	1,295,000.0	991,126.3	76.5
1.1. Иргэний орлогын албан татвар	970,000.0	660,225.1	68.1
1.2. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	325,000.0	330,901.2	101.8
2. Өмчийн татвар	16,000.0	9,594.7	60.0
2.1. Бууны албан татвар	16,000.0	9,594.7	60.0
3. Дотоодын бараа үйлчилгээний татвар	17,000.0	14,306.0	84.2
3.1. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар			
3.2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	17,000.0	14,306.0	84.2
4. Бусад татвар	866,650.0	799,408.7	92.2
4.1. улсын тэмдэгтийн хураамж	255,000.0	180,540.6	70.8
4.2. Ус, рашаан ашигласны төлбөр	1,650.0		-
4.3. Хог хаягдалын хураамж	610,000.0	618,868.1	101.5
2. Татварын бус орлого	230,000.0	163,795.9	71.2
2.1. Хүү, торгуулийн орлого	175,000.0	67,901.6	38.8
2.2. Төсөвт газрын өөрийн орлого	35,000.0	49,240.4	140.7
2.3. бусад нэр заагдаагүй орлого	20,000.0	46,653.9	233.3
В. Тусламжийн орлого	1,899,411.0	1,697,084.4	89.3
3. Нийслэлийн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	1,697,084.4	1,697,084.4	100.0
4. Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг	202,326.6		-


Орон нутгийн төсвийн зарлагын 39.52 хувийг буюу 1478.2 сая төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардалд, 3.28 хувийг буюу 122.5 сая төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд, 6.53 хувийг буюу 244.3 ашиглалтын зардалд, 25.99 хувийг буюу 972.0 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд тус тус зарцуулсан байна.



II.2 Хэрэглээний үнэ

2017 оны 4-р сарын 28-ний өдрийн байдлаар өрхийн хэрэглээнд гол үүрэг гүйцэтгэдэг өргөн хэрэглээний барааны нэг болох түлшний үнэ Хангай захад нэг шуудай мод 1500 төгрөг, нэг шуудай нүүрс 2500 төгрөгийн үнэтэй байна.


Зураг -6. Шатахууны үнэ, 04-р сарын 28-ны байдлаар, төгрөгөөр




2017 оны 4 сарын 28-ний өдрийн байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг ШТС-уудад дундажаар АИ-92 шатахуун 1630 төгрөг, АИ-80 шатахуун 1480 төгрөг дизель түлш 1720 төгрөг байна.

Өргөн хэрэглээний хүнсний барааны нэг болох махны үнийг зарим дэлгүүрүүдээр харвал хонины ястай мах 1 кг нь Миний зах дэлгүүрт 6990 төгрөг, Дүүхээ 2 дэлгүүрт 4700 төгрөг, Хар хорин захад 5300 төгрөгийн үнэтэй байна. Харин үхрийн цул мах 1 кг нь Миний зах дэлгүүр 9190 төгрөг байхад Хар хорин зах дээр 7500 төгрөгийн үнэтэй байлаа.

Зураг -7. Нэг кг хонины ястай махны үнэ, төгрөгөөр 4-р сарын байдлаар




Зураг -8. Нэг кг үхрийн ястай махны дундаж үнэ, төгрөг, 2010-2017 оны 4-р сард



Зураг- 9. Алтан тариа ХХК –ны дээд гурилын үнэ /1кг-төгрөг/ 2017 оны 04-р сарын байдлаар



Зураг- 10. Хүнсний ногооны дундаж үнэ, төгрөгөөр 2017 оны 4-р сарын байдлаар



Миний зах, Макс супер маркет, Хар хорин захуудын төмс, хүнсний ногооны үнийг харьцуулбал төмс 1 кг нь Хар хорин захад 600 төгрөг, Миний зах дэлгүүрт 690 төгрөг, байна. Дүүхээ 2 дэлгүүрт 600 төгрөг, БОСА дэлгүүрт 750 төгрөг байхад Гүнгэрваа захад 800 төгрөгийн үнэтэй байна. Харин лууван 1 кг нь Хар хорин зах дээр 1000 төгрөг, Миний дэлгүүрт 890 төгрөг, Макс супер маркетэд 1550 төгрөг байна.

Хүснэгт 10. Хэрэглээний үнэ, дүүргийн зарим хүнсний дэлгүүрээр 4-р сарын 28 ны байдлаар

	Миний зах Саппоро	Мах супермаркет	Хангалуун трейд ХХК	Хар хорин зах	Гүнгэрваа	БОСА	ДҮҮХЭЭ2	Дундаж үнэ
Гурил, дээдийн дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улбар шар/	0	1650	1600	1500	1600	1710	0	1612
Гурил, дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улаан/	1240	1350	1310	1300	1350	1300	1260	1301
Гурил, 2-р зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /ногоон/	800	0	850	0	900	820	0	843
Гоймон, дотоод, Алтан тариа, /улбар шар/	2400	2700	2500	1950	0	2300	0	2370
Цагаан будаа, кг, задгай	2400	2500	2500	2400	2500	2500	2450	2464
Хонины ястай мах, кг	6990	5350	0	5300	5200	0	4700	5508
Үхрийн ястай мах, кг	8890	6650	0	6300	6550	0	6000	6878
Үхрийн гуяны цул мах, кг	9190	7850	0	7500	8500	0	7000	8008
Адууны ястай мах, кг	5200	0	0	5100	4500	0	4000	4700
Ямааны ястай мах, кг	0	0	0	5000	4200	0	0	4600
Хиам, хагас утлагатай, "Сальям", "Траст Трейд" ХК	7330	7230	7600	7000	0	7300	7300	7293.333
Сүү, задгай, литр	1800	0	0	1700	1700	0	0	1733
Сүү, савласан, "Элекстер", 500 гр	1150	1100	1150	1000	1200	1080	1150	1119
Сүү, хайрцагтай, 1л, "Шинэ Сүү", "Сүү" ХК	2400	2200	2500	2300	2500	2520	2300	2389
Цэцгийн тос, 200 гр, "Сүү"ХК	3300	3180	3300	3200	0	3300	3200	3247
Өндөг	350	360	350	350	350	350	350	351
Төмс, Монгол, кг	690	750	810	600	800	750	600	714
Лууван, дотоод, кг	890	1550	1500	1000	1450	1000	0	1232
Манжин, дотоод, кг	1290	2000	1800	1500	0	1600	0	1638
Байцаа, Хятад, кг	1790	2000	2000	1500	1800	1900	1500	1784
Сонгино, Хятад, кг	1190	1450	1300	1300	1500	1200	1200	1306
Алим, "Фүжи" хятад, кг	4900	4600	5000	4400	4600	5300	4990	4827
Элсэн чихэр, кг, орос	2400	2300	2300	2000	2300	2200	2300	2257
Ёотон, орос, 500гр	2000	1800	2000	1700	2000	1800	1700	1857.143
Хатуу чихэр, "Барбарис", орос, 1 кг	4900	4800	5000	5000	5000	4900	4800	4914
Шоколад, "Alpen Gold"	1950	1850	2100	2000	2200	2100	2000	2029
Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	750	700	700	700	700	800	700	721
Ногоон цай, савласан, Гүрж	0	0	7500	7500	7500	0	0	7500
Пиво, "Боргио", 0.5 л, "АПУ" ХК	1350	1310	1400	1300	0	1400	1350	1352



II.3 Мал аж ахуй

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 4-р сарын байдлаар 21253 толгой эх мал төллөж, 21036 төл бойжиж байна, Төл бойжилт 98.90 хувь байна,

Хүснэгт 11. Мал төллөлт, төл бойжилт


Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:			
		Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	21278	367	7140	7322	6449
Хорогдсон төл	242	1	98	82	61
Бойжсон төл	21036	366	7042	7240	6388
Төл бойжилт	98.9	99.7	98.6	98.9	99.1

Оны эхний 4 сарын байдлаар 226 толгой том мал зүй бусаар хорогджээ. Зүй бусаар хорогдсон малын 28.32 хувийг үхэр, 32.74 хувийг хонь, 37.17 хувийг ямаа тус тус эзэлж байна. Нийт зүй бус хорогдлыг 28.76 хувийг өвчнөөр хорогдсон мал эзэлж байна.

Хүснэгт 12. Том малын зүй бус хорогдол

Том малын зүй бус хорогдол	Бүгд	Үүнээс:			
		адуу	үхэр	хонь	ямаа
Хорогдсон том мал бүгд	226	4	64	74	84
Үүнээс: өвчнөөр хорогдсон	65	2	18	25	20
Хорогдсон хээлтэгч	39	0	16	12	11

Зураг-11. Том малын зүй бус хорогдол, төрлөөр, хувиар,





II.4 Аж үйлдвэр

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 4-р сарын байдлаар байдлаар 91.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 102.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. Харин нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 4-р сарын байдлаар 2352.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2639.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Тайлант хугацаанд дүүргийн аж үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нийслэлийн үйлдвэрлэлтийн 3.47 хувь, борлуулалтын 3.86 хувийг эзэлж байна.

Дүүргийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 96.99 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт эзэлж байгаа бөгөөд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн 31.18 хувийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэлт эзэлж байна. Нийт бүтээгдэхүүн борлуулалтын 3.41 хувийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 28.73 хувийг эзэлж байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс борлуулалтын хэмжээ давсан байгаа боловч мах, сүү, гурлын бүтээгдэхүүн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 13. Дүүргийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, сая төгрөгөөр

	Үйлдвэрлэл 2017 оны /1-4 сараар/	Борлуулалт 2017 оны /1-4 сараар/
Нийт	91543.2	102022.7
Боловсруулах үйлдвэрлэл	91543.2	102022.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	88791.7	98542.3
Мах, махан бүтээгдэхүүн	10448	9435.3
Сүү, сүүн бүтээгдэхүүн	26304.4	26680.6
Үр тарианы гурил, малын тэжээл	28576.4	27955.8
Архи, ус, ундаа	11171.4	18108.5
Хүнсний бусад	12291.5	16362.1
Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2751.5	3480.4
Химийн бүтээгдэхүүн	1810.5	2141.8
Машин, төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	67.9	58.7
Резинэн эдлэл болон хуванцар бүтээгдэхүүн	40.3	40.3
Бусад үйлдвэрлэл	832.8	1239.6

Дүүргийн аж үйлдвэрийн газаруудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн өнгөрсөн оны мөн үеэс 21.87 хувиар буюу 16.4 тэр бум төгрөгөөр өссөн байна. Борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 15.91 хувиар буюу 14.0 тэр бум төгрөгөөр өссөн байна

Зураг- 12. Аж үйлдвэрийн 2017.04 сарын үйлдвэрлэлт борлуулалт/сая. төг/





II.5 Аж ахуй нэгж, байгууллага

Оны эхний 4 сарын байдлаар дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 15672 болсон байна. Тайлант хугацаанд 450 аж ахуйн нэгж, байгууллага шинээр бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын 83.48 хувь нь ХХК байна.


Хүснэгт 14. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төрлөөр 2017.04 сард

Төрөл	Хариуцлагын хэлбэр	2017.01.01-ны өдөр	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.04.30-ны өдөр
ААН	ХК	14			14
	ХХК	12720	377	14	13083
	ББН	147			147
	ЗБН	129			129
	ХХН	13			13
	Хоршоо	114	3		117
	Хад.Зээл хоршоо	66	2		68
	ТӨҮГ	8			8
	ОНӨҮГ	11			11
	Салбар	487	6	1	492
	Төлөөлөгчийн газар	3			3
	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2			2
	Боловсрол сургалтын байгууллага	7	1		8
	Нийт		13721	389	15
Төсөвт болон ТТБ	Төсөвт байгууллага	135	2		137
	Төрийн бус байгууллага	1107	48		1155
	Шашны байгууллага	52			52
	сан	50	4		54
	Олон нийтийн байгууллага	172	7		179
	Нийт		1516	61	
Бүгд		15237	450	15	15672

Зураг- 13. Бүртгэлтэй ААНБайгууллагуудын тоо төрлөөр, хувиар



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Download on the
App Store

Google play

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Утсаар:



Лавлах утас

1900-1212



Холбоо барих

18082 Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг
27-р хороо Агарын гудамж
Дэлхийн зөн ОУБ-ын байр
Утас: 70171322, 70171660
И-мэйл: Songinokhairkhan@nso.mn
Вэб: www.ubstat.mn
www.shd.mn

